



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Тохжилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан,
тодруулгад хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/007/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт хот
2025 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Г.Даваа
Утас: 70518396
Аудитын менежер: М.Нарантуяа
Утас: 70512123
Аудитор: Ө.Золзаяа
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.03.17 № 295

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Баруун-Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 27/03 дугаар тогтоолоор зарлагыг 380.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Аудитын гол асуудал

Баруун-Урт сумын гэр хорооллын борооны усанд автсан гудамж, талбайн тэгшилгээний 220.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг цахим системд зарлал байршуулалгүй шууд гэрээ байгуулсан нь худалдан авах ажиллагааны ил тод байдал, өрсөлдөөний зарчим зөрчигдөх, шийдвэр гаргалтын хариуцлага, үр ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдүүлсэн байна.

Бусад асуудал

D:\Бичиг хэрэг\2025\Явсан бичиг\A4 тоот 2025.docx

2225070129

Сүхбаатар аймгийн Тохжилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар батлуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, тодруулга нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Дансны код	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
А	Б		1	2
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		37,571,272.28	102,043,600.84
1.1.1.2	Банкин дахь мөнгө	1101	37,571,272.28	102,043,600.84
1.1.2	Дансны авлага		-	2,070,000.00
1.1.2.2	Борлуулалтын авлага	1204	-	2,070,000.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		374,371.32	1,394,505.76
1.1.3.1	НӨАТ-ын тооцоо	1206	374,371.32	1,351,528.68
1.1.3.3	ХХОАТ-ын тооцоо /Суутган-1/	1208	-	30,000.00
1.1.3.6	ЭМНД-ийн шимтгэлийн тооцоо	1210	-	12,977.09
1.1.4	Бусад авлага		218,726.13	0.02
1.1.4.1	Хувь хүнээс авах авлага	1201	218,726.13	0.02
1.1.6	Бараа материал		178,409,869.53	184,820,890.78
1.1.6.1	Түүхий эд материал	1401	3,171,800.00	4,509,300.00
1.1.6.3	Бэлэн бүтээгдэхүүн	1403	704,600.00	704,600.00
1.1.6.4	Хангамжын материал	1501	149,072,051.36	166,853,345.33
1.1.6.5	Сэлбэг хэрэгсэл	1502	25,461,418.18	12,753,645.45
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		10,360,543.26	9,383,521.40
1.1.7.2	Урьдчилж төлсөн түрээс, даатгал	1602	10,360,543.26	9,383,521.40
	Эргэлтийн хөрөнгийн дүн		226,934,782.53	299,712,518.80
1.2.1	Үндсэн хөрөнгө		6,779,440,177.48	5,661,722,638.48
1.2.1.2	Барилга байгууламж	2001	6,507,354,484.64	6,507,354,484.64
1.2.1.3	Хуримтлагдсан элэгдэл. Барилга	2011	(2,809,371,637.16)	(3,366,469,949.39)
1.2.1.4	Машин, тоног төхөөрөмж	2002	275,028,840.58	286,008,840.58
1.2.1.5	Хуримтлагдсан элэгдэл. МТТ	2012	(24,352,248.27)	(55,315,234.76)
1.2.1.6	Тээврийн хэрэгсэл	2003	894,318,300.00	1,064,268,300.00
1.2.1.7	Хуримтлагдсан элэгдэл. Тээвэр	2013	(351,346,841.67)	(432,453,091.67)
1.2.1.8	Тавилга эд хогшил	2004	12,191,315.00	15,735,215.00
1.2.1.9	Хуримтлагдсан элэгдэл. ТЭХ	2014	(6,331,479.76)	(7,000,875.04)
1.2.1.10	Компьютер, бусад хэрэгсэл	2005	21,401,481.04	25,261,381.04
1.2.1.11	Хуримтлагдсан элэгдэл. Компьютер	2015	(15,952,312.52)	(20,565,087.21)
1.2.1.12	Бусад үндсэн хөрөнгө	2006	7,666,563,100.04	7,666,563,100.04
1.2.1.13	Хуримтлагдсан элэгдэл. БҮХ	2016	(5,390,062,824.43)	(6,021,664,444.75)
1.2.2	Биет бус хөрөнгө		176,156,262.60	173,829,096.29
1.2.2.13	Бусад биет бус хөрөнгө	2107	177,169,665.22	177,169,665.22
1.2.2.14	Хуримтлагдсан элэгдэл. Бусад биет бус хөрөнгө	2117	(1,013,402.63)	(3,340,568.93)
1.2.1	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		6,955,596,440.08	5,835,551,734.77
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		7,182,531,222.60	6,135,264,253.57
2.1.1.1	Дансны өглөг		7,397,656.02	2,403,781.02
2.1.1.1.1	Бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг	3106	7,397,656.02	2,403,781.02
2.1.1.2	Цалингийн өглөг	3105	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр		0.00	1,394,945.11
2.1.1.3.2	Орлогын татварын тооцоо		-	1,394,945.11
-	ААНОАТ тооцоо /ТТ-02 Нийтлэг/	1207	-	1,394,945.11
2.1.1.3.3	ХХОАТ-ын тооцоо /Суутган-1/	1208	0.00	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3206	7,627,115,473.26	6,579,498,690.26
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3209	12,100,620.00	12,334,510.32
2.1.1.1.1	Байгууллагад өгөх өглөг	3101	10,681,000.00	10,884,890.32
2.1.1.1.2	Хувь хүнд өгөх өглөг	3102	1,419,620.00	1,449,620.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		7,646,613,749.29	6,595,631,926.71
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн		7,646,613,749.29	6,595,631,926.71
2.3.1	Төрийн өмч	4101	4,334,716,228.00	4,334,716,228.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		4,942,238,332.33	4,942,238,332.33
2.3.6.1	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	4106	4,942,238,332.33	4,942,238,332.33
2.3.9	Хуримтлагдсан ашиг:		(9,741,037,087.01)	(9,737,322,233.47)
2.3.9.1	Тайлант үеийн ашиг	4112	-	3,714,853.54
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	4113	(9,741,037,087.01)	(9,741,037,087.01)
2.3.11	Эздийн өмчийн дүн		(464,082,526.68)	(460,367,673.15)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		7,182,531,222.61	6,135,264,253.57

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт		2023 ОНЫ 12 САРЫН 31	2024 ОНЫ 12 САРЫН 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		116,486,493.89	112,146,477.27
1.1	Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	5101	116,413,766.62	112,146,477.27
1.2	Ажил үйлчилгээ борлуулсны орлого	5102	72,727.27	-
2	Борлуулалтын өртөг		16,800.00	-
2.1	Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг		16,800.00	-
-	Шууд материалын зардал /ТЭМЗ/	6101	16,800.00	-
3	Нийт ашиг /алдагдал/		116,469,693.89	112,146,477.27
4	Түрээсийн орлого	5103	3,313,636.36	1,636,363.64
5	Хүүний орлого	5104	128,897.30	1,037,895.60
8	Бусад орлого		2,571,278,543.73	3,304,283,290.00
	Бусад орлого	8401	42,839,638.00	121,336,581.98
	Үйл ажиллагааны бус орлого	8403	1,325,997,605.73	1,274,910,508.02
	Санхүүжилтийн орлого	8406	1,202,441,300.00	1,908,036,200.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		1,187,234,963.78	1,883,672,552.65
-	Ажиллагчдын цалингийн зардал	7001	519,449,114.08	880,247,268.25
-	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	7002	74,799,236.01	117,973,213.03
-	Албан татвар, төлбөр, хураамж	7003	993,616.00	1,020,682.00
-	Томилолтын зардал	7004		400,000.00
-	Бичиг хэргийн зардал	7005	6,250.00	-
-	Шуудан холбооны зардал	7006	1,010,272.73	695,454.55
-	Мэргэжлийн үйлчилгээний зардал	7007	128,055,143.28	123,406,125.00
-	Даатгалын зардал	7010	1,406,218.50	879,791.16
-	Ашиглалтын зардал	7011	1,919,724.12	3,659,620.00
-	Түрээсийн зардал	7014		37,800,000.00
-	Тээврийн зардал	7017	3,475,000.00	3,400,000.00
-	Шатахууны зардал	7018	203,221,415.78	198,672,345.51
-	Бусад зардал	7023	252,898,973.28	515,518,053.15
10	Ерөнхий ба удирдлагын зардал		1,538,723,180.32	1,506,700,794.37
-	Ажиллагчдын цалингийн зардал	7001	86,386,409.63	118,166,384.65
-	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	7002	12,526,029.40	14,770,798.08
-	Албан татвар, төлбөр, хураамж	7003	530,001.00	628,460.00
-	Томилолтын зардал	7004	3,408,000.00	1,300,000.00
-	Бичиг хэргийн зардал	7005	2,400,529.09	1,974,900.00
-	Шуудан холбооны зардал	7006	1,860,401.14	2,173,668.36
-	Сургалтын зардал	7008	300,000.00	100,000.00
-	Даатгалын зардал	7010	74,011.50	66,220.84
-	Ашиглалтын зардал	7011	15,457,912.04	16,846,066.30
-	Элэгдэл, хорогдлын зардал	7013	1,376,760,913.92	1,308,378,505.31
-	Тээврийн зардал	7017	175,000.00	-
-	Шатахууны зардал	7018	17,687,151.05	28,992,497.46
-	Бусад зардал	7023	21,156,821.55	13,303,293.36
12	Бусад зардал /ҮАБЗ/		10,827,190.00	22,100,758.00
-	Торгууль алдангийн зардал	8702	410,000.00	9,278,950.00

-	Үйл ажиллагааны бус зардал	8705	10,417,190.00	12,821,808.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(45,594,562.82)	6,629,921.49
19	Орлогын татварын зардал		12,889.73	2,915,067.95
-	Тайлангийн үеийн орлогын татварын зардал	9101	12,889.73	2,915,067.95
20	Татварын дараах ашиг (алдагдал)		(45,607,452.55)	3,714,853.54
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		(45,607,452.55)	3,714,853.54
24	Орлогын нийт дүн		(45,607,452.55)	3,714,853.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	1,378,195,341.28	2,178,754,892.98
	1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	129,269,403.28	121,291,125.00
	1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого	<u>1,202,441,300.00</u>	1,908,036,200.00
	1.1.6 Бусад мөнгөн орлого	46,484,638.00	149,427,567.98
1.2	<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	1,373,752,802.24	2,097,277,325.59
	1.2.1 Ажилчдад төлсөн	496,329,647.67	810,806,919.12
	1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	155,947,465.11	245,194,845.68
	1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	251,006,976.00	410,746,039.20
	1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	18,191,171.92	21,842,308.30
	1.2.5 Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	219,559,919.00	218,618,549.00
	1.2.7 Татварын байгууллагад төлсөн	40,629,714.60	76,149,288.77
	1.2.8 Бусад мөнгөн зарлага	192,087,907.94	313,919,375.52
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,442,539.04	81,477,567.39
2.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	116,007.59	1,152,832.17
	2.1.5 Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.02	218,726.13
	2.1.6 Хүлээн авсан хүүний орлого	116,007.57	934,106.04
2.2	<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	21,049,900.00	18,383,800.00
	2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	21,049,900.00	18,383,800.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(20,933,892.41)	(17,230,967.83)
3.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	3,291,832.12	1,576,265.00
	3.1.1 Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,291,832.12	1,576,265.00
3.2	<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>		1,350,536.00
	3.2.1 Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,291,832.12	1,350,536.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,291,832.12	225,729.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(16,491,353.38)	64,472,328.56
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,062,625.66	37,571,272.28
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,571,272.28	102,043,600.84

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Эдийн засгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	3	5	6

Бараа бүтээгдэхүүн борлуулалтын орлого	мян.төг	127,000.00	112,146.48
Түрээсийн орлого	мян.төг	1,800.00	1,636.36
Санхүүжилтийн орлого	мян.төг	2,067,636.20	1,908,036.20
Бусад орлого	мян.төг	1,285,654.92	1,397,284.99
Нийт орлого	мян.төг	3,482,091.12	3,419,104.03
үйл ажиллагааны бус орлого		1,285,654.92	1,324,914.09
Нийт зардал	мян.төг	3,095,291.12	3,412,474.11
Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	1,414,324.27	1,506,700.79
Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	386,800.00	2,915.07
Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	1,620.00	3,714.85
Нийт ажиллагсдын тоо	мян.төг	72	62
Нийт цалингийн сан	мян.төг	1,048,452.00	998,413.65
Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,213.49	1,341.95
Хөрөнгө оруулалт		9,000.00	10,724.90
Нийт өглөг	мян.төг	6,341,460.55	7,627,115.47
Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	мян.төг	6,341,460.55	7,627,115.47
Урт хугацаат өр төлбөр			

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,019.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 3 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Хоолны зардлыг Баруун-Урт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан хэмжээнээс 6,019.3 мянган төгрөгөөр илүү зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” дахь заалт, Баруун-Урт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 27/03 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Зөвлөмж : Хоолны зардлыг батлагдсан хэмжээнд нийцүүлэн төсөвлөх, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, зардлын хэтрэлтийг арилгаж, төсвийн сахилга бат, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авах

Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

3.1.2 Илрүүлэлт:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 “онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй” дахь заалтын дагуу гудамж, талбайн тэгшилгээний 220,000.0 мянган төгрөгийн ажлыг “Гайхамшигт уул” ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна.
- Ажилчдын нормын хувцсыг нийт дүнгээр (22,040.0 мянган төгрөг) төлөвлөлгүй, хэсэгчлэн худалдан авалт хийсэн.

- Худалдан авах ажиллагааны босго үнийг баримтлалгүй 23,611.2 мянган төгрөгийн худалдан авалт зохион байгуулсан

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 35 дугаар зүйлийн 35.2 “Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ”, 35.4 “Хэлэлцээнд оролцох сонирхлоо илэрхийлэх хугацааг зарлал нийтэлж, урилга хүргүүлснээс хойш ажлын таван өдөр байхаар, хэлэлцээ эхлүүлэх хугацааг сонирхлоо илэрхийлэх эцсийн хугацаанаас хойш ажлын гурваас доошгүй өдөр байхаар зарлал, урилгад тус тус заана” дахь заалтууд, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар” -ыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах, худалдан авалтыг төсвийн дүнд нийцүүлэн төлөвлөж, хэсэгчлэн худалдан авахыг хориглох заалтыг чанд мөрдөх, шууд гэрээ байгуулах бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шаардлагыг хангасан тохиолдолд хийх, худалдан авалтын босго үнийг хэтрүүлэхгүй байх замаар төсвийн сахилга бат, ил тод байдал, өрсөлдөөнт орчныг хангаж ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зардлыг баталсан дүнгээс илүү зарцуулсан	1	6,019.3					1	6,019.3				
Дүн	1	6,019.3					1	6,019.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
ХАА-ны хууль, эрх зүйн баримт зөрчсөн	1	-			1	-
Нийт дүн	1	-			1	-